



СОЁМБОМ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№245 /454/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.01.12

Цаг үе, үйл явдал

САНГИЙН САЙД Б.ЖАВХЛАН: МОНГОЛ УЛС ДЕФОЛТ ЭРСДЭЛЭЭС БҮРЭН ГАРЛАА

Монгол Улсын Засгийн газраас Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд үр дүнгээ өгч төсвийн алдагдал 60 хувиар буурч, хөрөнгө оруулагчдын итгэл нэмэгдэж байна.

Экспорт, гадаад худалдаа сайжирч байна. Монгол Улсын Засгийн газраас эдийн засгаа сэргээхэд чиглэсэн боломжит бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд 2022 оны нэгдүгээр улиралд -3.9 хувьд хүрч унаад байсан эдийн засаг оны эцэст 4.0 орчим хувьд хүрч сайжирсан байна.

2023 оны эдийн засгийн төсөөлөл илүү эерэг болж байна. Засгийн газраас 2020 онд авч хэрэгжүүлсэн "Номад" өрийн зохицуулалтын арга хэмжээ, 2021 онд авч хэрэгжүүлсэн "Сенчири" өрийн зохицуулалтын арга хэмжээний үр дүнд 2022 оны арванхоёрдугаар сарын 5-ны өдөр эргэн төлөгдөх хуваарьтай Чингис бондын хоёрдугаар транч болох 10 жилийн хугацаатай, 5.125 хувийн хүүтэй, нийт 1.0 тэрбум ам.долларын дийлэнх хэсгийг дахин санхүүжүүлж, үлдээд байсан 136.8 сая ам.долларын төлбөрийн эргэн төлөлтийг 2022 оны арванхоёрдугаар сарын 5-нд бүрэн төлж барагдуулсан.

Монгол Улсын Хөгжлийн банкнаас авсан зээлийг эргэн төлүүлэх ажлыг эрчимжүүлснээр 2022 онд 994.7 тэрбум төгрөгийг татан



төвлөрүүлээ. Ингэснээр Засгийн газрын баталгаатай Самурай бондын эргэн төлөлтийг төлөх мөнгөн хөрөнгийг 100 хувь бүрдүүлж, цаашлаад 2022 оны эхэнд 1.3 хувь байсан өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт (CAR)-ийг зохистой түвшинд хүргэж тус банк дампуурах эрсдэлээс бүрэн гараад байна.

2023 онд Монгол Улсын Засгийн газрын төлөх бондын өрийн зохицуулалтыг хийх зорилгоор Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Монголбанк хамтран шуурхай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн хөрөнгө оруулагчдын цахим уулзалтуудыг хийснээр 2023 оны нэгдүгээр сарын 9-ний байдлаар 138 олон улсын хөрөнгө оруулагчдаас буюу Ази, Америк, Европын хөрөнгө оруулагчдаас дөрөв орчим тэрбум ам.долларын захиалгыг ирүүлснээр өмнөх өрийн зохицуулалтын арга хэмжээг амжилттай авч хэрэгжүүлээ.

Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Fitch, S&P, Moody's агентлагууд Монгол Улсын зээлжих зэрэглэлийг жил бүр үнэлдэг. Энэ хүрээнд Монгол Улсын зээлжих зэрэглэлийг "В, тогтвортой" төлөвт хэвээр хадгалжээ.

МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ

НЭГДСЭН ТӨСВИЙН УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААР...

Монгол Улсын Засгийн газраас эдийн засгаа сэргээхэд чиглэсэн боломжит бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд 2022 оны нэгдүгээр улиралд -3.9 хувьд хүрч унаад байсан эдийн засаг оны эцэст 4.0 орчим хувьд хүрч сайжирсан байна. Нэрлэсэн ДНБ 2022 онд 48 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 10 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ 28 их наяд төгрөгт хүрсэн байна. Эдийн засгийн өсөлтийг салбараар авч үзвэл хөдөө аж ахуй, уул уурхайн салбар болон бүтээгдэхүүний цэвэр татвар бодит өсөлтөд гол хувь нэмэр оруулсан байна. Монгол Улсын Засгийн газраас экспортыг эргэн сэргээхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд 2022 оны эхний хагаст 8.1 сая тонн буюу өмнөх оноос 12.7 хувиар агшаад байсан нүүрсний экспорт 2022 оны эцэст 31.6 сая тоннд хүрч 2021 оноос даруй хоёр дахин өссөн байна. Зэсийн баяжмалын хувьд 1.4 сая тонн экспортж, өмнөх оны мөн үеэс 11.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Ингэснээр АМНАТ-ийн орлого 2.7 их наяд төгрөгт хүрч, уул уурхайн орлого 4.1 их

наяд төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 750 орчим тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй гарсан байна. Төлбөрийн тэнцэл 2022 оны эцэст нэг тэрбум ам.долларын алдагдалтай гарч, гадаад валютын албан нөөц 3,399.6 сая ам.долларт хүрсэн. Уг нөөц нь валютын төлбөртэй барааны импортын нийт 4.7 сарын хэрэгцээг хангах түвшинд байна. Засгийн газраас 2022 оны аравдугаар сард "Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай" 362 дугаар тогтоол гаргаж хэрэгжүүлсэн нь гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэхэд нөлөөлж улмаар "Эрдэнэс Тавантолгой" ТӨХК, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Монголросцветмет" ТӨҮГ, "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-иуд болон "Оюу толгой" ХХК нийт 1.1 тэрбум гаруй ам.доллар улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Тухайлбал, "Эрдэнэс Тавантолгой" ТӨХК дээрх тогтоол батлагдсанаас хойш арванхоёрдугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацаанд 588.5 сая орчим ам.долларын үнийн дүн бүхий 6.6 сая тонн нүүрс борлуулжээ. Мөн өнгөрсөн онд арилжааны банкууд гадаадын банк, санхүүгийн байгууллагуудаас хэд хэдэн урт хугацаат санхүүжилтийг татсан нь валютын нөөц нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-18	-23

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
36	22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.471	3.475
EUR	3.720	3.745
CNY	512	514.50
RUB	48.30	49
JPY	26.30	26.70
KRW	2.84	2.87

ЗУРХАЙ



2022.01.12 / ПҮРЭВ ГАРАГ / БИЛГИЙН ТООЛЛЫН 20

ӨВЛИЙН ДУНД ХАР ХУЛГАНА САР ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ ЦАГААН МОРЬ ӨДӨР

Үс засуулбал: Өлсөж ундаасна Наран ургах, шингэх: 08.39-17.22 Барилдлага: Сэрэхүй Шүтэн барилдлага: Хурьцахуй

Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Эл өдөр санасан хэрэг түргэн бүтнэ. Бүтээл үйлдэх, тус чухалчлах, хэл ам дарах, башир, хатуу, түргэн үйлнээ сайн, амраг лугаа золгох, авшиг авах, ус гатлах, угаах зэрэгт сайн. Баруун нүд татвал садан ирэх, зүүн нүд татвал баярлах, баруун чих хангинавал гутамшиг болох, зүүн хангинавал завхарсныг сонсож цочих, бие татвал өмнө зүгээс зочин ирэх, хөл татвал хэрүүл гомдол болно.

ТӨЛӨВЛӨГӨӨТ СУРГАЛТААР...



БХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын баталсан "Цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангах, байгууллагын үйл ажиллагааны онцлогтой уялдуулан сургалт бэлтгэлийг зохион байгуулж, бие бүрэлдэхүүнийг ажлын байран дээр суралцан хөгжих, нөхцөл бололцоог нэмэгдүүлэх зорилгоор ЦДБЭЧ-ын бие бүрэлдэхүүний төлөвлөгөөт сургалтыг 1 дүгээр сарын 10-наас 11-ний өдрүүдэд зохион байгуулав.

Сургалтаар Хэл шинжлэлийн ухааны доктор СГЗ Л.Мөнхтөр, "Сэтгэл гэдэг эрхтэн", Батлан хамгаалах яамны Ёс зүйн зөвлөлийн нарийн бичгийн дарга, ХШУДАГ-ын

батлан хамгаалах бодлого, орон нутгийн хамгаалалтын үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн дэд хурандаа Ц.Санчир "Ёс суртахуун ба ёс зүйн үндсэн асуудал", "Ёс зүйтэй шийдвэр гаргалт", Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн ажлын албаны мэргэжилтэн, Иргэний зөвлөлийн нарийн бичгийн дарга хошууч А.Октябрь, Отгонтэнгэр их сургуулийн багш, доктор, профессор, МУГБ Б.Галиндэв "Эх оронч үзэл", Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэнгийн тэнхимийн дарга, доктор хошууч Т.Сүхбаатар "Монгол цэргийн түүх уламжлал", ҮБХИС-ийн ЦНДС-ийн Сэтгэл зүйн хангалтын багш, ахлах дэслэгч Г.Амгалан "Цэргийн албан хаагчийн сэтгэл зүй, үнэт зүйлс", ХСҮТ-



ийн үйлчлүүлэгчийг дэмжих албаны дарга, их эмч Л. Энхээ "Хавдрын эрсдэлт хүчин зүйл, түүнээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг", Батлан хамгаалах удирдлагын академийн багш Т.Тулга "Олон улсын тойм, Зэвсэгт хүчний байдал", ХХБ-ны зээлийн эдийн засагч Б.Андуурал, данс хариуцсан ажилтан Д.Энхмаа "Худалдаа хөгжлийн банкны үйл ажиллагаа, иргэдэд чиглэсэн үйлчилгээ", ХӨСҮТ-ийн Хандалт судалгааны албаны Эрт сэрэмжлүүлэг, хариу арга хэмжээ авах нэгжийн дарга Н.Сувдмаа "Амьсгалын замын халдвар, түүнээс урьдчилан сэргийлэх сайн дурын дархлаажуулалт, зөвлөмж", Өглөөний гайхамшиг монгол төслийн санаачлагч, Грандбук Пабблишингийн

үүсгэн байгуулагч, редактор Д. Гэрэлмаа "Өглөөний гайхамшиг-ахиц, амжилт, аз жаргал", "BDSEC" үнэт цаасны компанийн харилцааны ажилтан С.Дөлгөөн "Үнэт цаасны арилжаа" зэрэг сэдвүүдийн хүрээнд нийт 17 цагийн багц сургалтыг зохион байгуулав.

Уг сургалт нь ЦДБЭЧ-ын бие бүрэлдэхүүний ёс зүй, хувь хүний хөгжил, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын асуудлуудад чиглэсэн үр дүнтэй сургалт болж өндөрлөсөн юм.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 669,893,308

Эдгэрсэн Нийт: 641,199,026

Нас барсан Нийт: 6,720,910

Цахим шууданд

ЭХ ОРНЫ ХҮҮД ЭЭЖИЙН ЗАХИАС...



ҮБХИС-ийн Харуул үйлчилгээний ротын хугацаат албаны түрүүч, байлдагчдын алба хаах итгэл, үнэмшил, урам зоригийг дээшлүүлэх зорилгоор "Эх орны хүүд ээжийн захиас" хүндэтгэлийн уулзалтыг зохион байгууллаа.

Энэхүү уулзалтад Сонгино хайрхан дүүргийн 21 дүгээр хорооны иргэн Л.Сарангэрэлийг урьж оролцуулсан юм. Тэрээр дөрвөн хүүхдийн ээж бөгөөд ууган хүү Т.Төрболд

нь 2019 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагаар Зэвсэгт хүчний 326 дугаар ангид хугацаат цэргийн алба хаасан бол удаах хүү Т.Улсболд нь "Тэмүүжин Өрлөг" сургуулийн аравдугаар ангид суралцдаг.

Зочин ээж маань бидний саналыг хүлээн аваад маш их баярлаж догдолсны зэрэгцээ яг л хүү дээрээ эргэлтээр очих гэж байгаа мэт догдлон байж ирснээ онцолж байсан юм.

Тэрээр хугацаат цэргийн алба хаагчидтай уулзах үеэрээ "Эрхэм хүндэт түрүүч, байлдагч, ирээдүйн эх орны эзэд, өрх гэрийн ноён нуруу та бүхнийг цэргийн алба хаах чухал шийдвэр гаргаж эх орондоо үнэнчйин баталгаа болсон эр цэргийн тангараг өргөн эх орны хүү болсныг харах сайхан байна. Цэргийн алба хааснаар хувь хүний бие махбод, сэтгэл зүй болоод амьдралыг харах өнцөг, аливаад хандах хандлага гээд олон талын өөрчлөлт гардаг. Тухайлбал, бие бялдрын өв тэгш хүмүүжлийг цогцлоохоос гадна амьдралд тулгарах аливаа бэрхшээлд сэтгэлийн хаттай байхад цэргийн алба сургадаг. Товчхондоо энх цагт эр цэргийн алба хаана гэдэг эх орны энхийн манаанд зогсож хувь хүн ахин хүмүүждэг, төлөвшдөг, өөрийгөө танин мэддэг, шинээр бүтээгддэг билээ. Мөн өнөөдрийн нийгэмд цэргийн алба хаана гэдэг нь асар нэр хүндтэй бөгөөд ажил, албан тушаалд томилогдоход чухал шалгуур үзүүлэлтийн нэг болсон гэдгийг та бүхэн надаар хэлүүлэлтгүй сайн мэдэж байгаа биз ээ. Сая хэлсэнчлэн та бүхэн цэргийн өдөр тутмын бэлтгэл, сургуулилтаа хамрагдах явцдаа амьдралд хэрэг болохуйц олон эерэг дадал зуршлыг өөртөө бий болгож буйгаа төдийлөн анзаардаггүй байх. Та бүхний энэхүү өөрчлөлт нь цэргийн алба хаасны дараа аав, ээж хайртай дотны хүмүүст маш тодоор харагддаг. Төгсгөлд нь та бүгдэд аминчлан захи зүйл бол цэргийн алба хааж буй энэ цаг хугацааг өөрийгөө хөгжүүлэх боломж гэж хараарай. Дарга нарынхаа үгэнд сайн ороорой, хоорондоо эв эеийг хичээж, нэг насны найзууд болоорой" хэмээгээд байлдагч бүрийн алгыг атга чихрээр мялаасан юм.

Сургалтын төгсгөлд бас нэгэн баярт мөч тохиосон нь ээжтэйгээ үл ойлголцсон байсан

гуравдугаар салааны байлдагч А.Эрдэнэбилэг ээжтэйгээ цахимаар уулзсан явдал байлаа. Байлдагч маань ээждээ чин сэтгэлийн үгээ илэрхийлсний дараагаар хамт алба хааж буй нөхөд нь нижигнэсэн алга ташилтаар ээж, хүү хоёрыг мялаав. Ийнхүү алба хаах итгэл үнэмшил дүүрэн хүү, эх орны хүүгээрээ бахархах сэтгэл дүүрэн ээж хоёрын сэтгэл догдлуулсан халуун ярилцлагаар энэ удаагийн арга хэмжээ өндөрлөлөө.

Ахмад Д.ГАНЦЭЦЭГ



ӨВЛИЙН СПОРТЫН АВАРГУУДАА ТОДРУУЛНА



Зэвсэгт хүчний 2023 оны аварга шалгаруулах Цэрэгжлийн спортын өвлийн 2 төрөлт, ЦСЦ-ын өвлийн олон төрөлтийн тэмцээний бэлтгэл энэ өдрүүдэд Хужирбулан дахь сургалтын төвд явагдаж байна.

Энэ жилийн тэмцээнд Зэвсэгт хүчний 20 гаруй анги, байгууллагын 180 орчим цэргийн алба хаагч оролцож байгаа бөгөөд тэдний 15 гаруй хувь нь олон улсын хэмжээний болон

цэрэгжлийн спортын мастер, зэрэг цолтой тамирчид юм.

Тэмцээн 1 дүгээр сарын 16-20-ны өдрүүдэд явагдана. Өвлийн улиралд явагддаг энэхүү цогцолбор тэмцээн нь цэргийн алба хаагчдын өвлийн сургалт бэлтгэл, байлдааны бэлтгэлийн үндсэн суурь болж өгөхөөс гадна эр зориг, тэсвэр тэвчээрийн илэрхийлэл, тэднийг бэлтгэх, сургах, дадлагажуулах нэг хэлбэр юм.

ТҮРҮҮЧ, БАЙЛДАГЧ НАР ДӨРВӨН ЦЭГТ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭВ



Цэргийн гавьяаны одонт Зэвсэгт хүчний 326 дугаар анги 2022-2023 сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу хугацаат цэргийн алба хаагчдын бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлийг дээшлүүлэх зорилгоор тактик, тусгай бэлтгэлийн цогцолбор 30 км явган маршийг 1

дүгээр сарын 11-ний энэ өдөр зохион байгуулж явууллаа.

Маршийн явцад хугацаат цэргүүд тактикийн ажиллагаа, буудлагын дасгал боловсруулах, химийн норматив, байр зүйн цэгүүдэд үүрэг гүйцэтгэж, дадлага, ур чадвараа нэмэгдүүллээ.

Зарлал

ЗӨВЛӨХ ИНЖЕНЕРИЙН СУРГАЛТ ЯВАГДАХ ГЭЖ БАЙНА

Монгол Улсын Батлан хамгаалахын сайдын тушаалаар Батлан хамгаалах салбарын цэргийн инженерийн мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох, магадлан итгэмжлэх зөвлөл байгуулагдаж тус зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм, журам шинэчлэн батлагдлаа.

ҮБХИС-ийн ЦНДС-ийн Цэргийн инженер, химийн тэнхим, "Инженерийн цэргийн холбоо" ТББ хамтран мэргэшсэн болон зөвлөх инженерийн сургалтыг 2023 оны 1 дүгээр сарын 16-ны өдрөөс явуулахаар төлөвлөж байна.

Иймд мэргэшлийн зэрэг горилочид дэлгэрэнгүй мэдээллийг /ҮБХИС-ийн <http://mndu.gov.mn> сайт болон 88076595, 99896595 дугаарт/ холбогдож авна уу.

Жич: Бүртгүүлэхээр ирэхдээ дараах материалыг бүрдүүлж ирнэ үү

- Үүнд:
1. Зэрэг горилохыг хүссэн хувийн өргөдөл: Өргөдөлийг батлагдсан маягтаар гаргана. /Өргөдөлийн маягтыг нэгдүгээр хавсралтаар гаргана/
 2. Ажил байдлын тодорхойлолт: Тодорхойлолтыг тухайн хүний үндсэн байгууллагаас тодорхойлж, удирдлага нь гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсан байна. Шаардлагатай гэж үзвэл харъяалагдах дээд байгууллагын тодорхойлолт гаргаж болно.
 3. 3x4 хэмжээтэй 2 хувь зураг/файлаар/
 4. Дээд боловсролын үнэмлэх, дипломын хуулбар: Дээд боловсролын үнэмлэх, дипломын хуулбарыг нотариатаар баталгаажуулах, хэрэв баталгаажуулаагүй бол хуулбарыг эхтэй нь тулгаж хүлээж авна. /Гадаадад зэрэг хамгаалсан бол орчуулгын товчоогоор орчуулуулж, баталгаажуулсан байх/
 5. Бүтээлийн тайлан, жагсаалт: Бүтээлийн тайлан жагсаалтыг үндсэн байгууллагын удирдах ажилтан ба зөвлөх зэрэгтэй хоёроос доошгүй мэргэжилтэн хянаж баталгаажуулсан байна. Бүтээлийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар гаргана. /Хүснэгтийн загвар доор бий/
 6. Иргэний үнэмлэхний хуулбар/баталгаажуулсан байна/
 7. Сургалт шалгаруулалттай холбогдсон төлбөрийн баримт: Төлбөрийг бэлнээр буюу дансаар төлж болно.

Гэрэл зургийн фондоос



Монголын алтан соёмбыг африк залуу ийн урлажээ. Энхийг сахиулагчид байгаа газар орондоо эх орноо сурталчлах үзэл, бахархлыг түгээж байна